



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 10 сарын 27 өдөр

Дугаар А/567

Есөнбулаг сум

Гэрээ шууд байгуулах эрх
олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсэг, 48 дугаар зүйлийн 48.3 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Төрийн албан хаагчдад Хөрөнгийн зах зээл болон төр, хувийн хэвшлийн түншлэлээр төсвийн бус эх үүсвэрийг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалтын сангийн зохицуулалтаар санхүүгийн менежмент хийх боломжийн чиглэлээр сургалт зохион байгуулах ажлыг "Бодит хүч" ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлэх эрхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ш.Эрдэнэбат)-д олгосугай.

2.Шаардагдах 19,800,000 (арван есөн сая найман зуун мянга) төгрөгийг хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ш.Эрдэнэбат)-д зөвшөөрсүгэй.

3.Ажлын гүйцэтгэл, чанар, санхүүжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын хэлтэс (Я.Жаргалцэцэг), Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Д.Буянхишиг)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ

